



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/517

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хужирт сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажил дууссан тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (Т.Ариунболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 1033

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 20-ны өдрийн 457 дугаар
захирамжийн хавсралт



**ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Г.Балжинням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гамшигаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)

Д.Цэцэгмаа (Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Ш.Эрдэнэхорол (Хужирт сумын цэцэрлэгийн эрхлэгч)

Э.Батбаяр ("Онги-Ус суваг" ОНӨААТҮГ-ын Хужирт сум хариуцсан албаны дарга)

Б.Цэрэнсодном ("ЭБЦТС ТӨХК"-ийн Хархорин суман аймаг дахь салбарын ахлах инженер)

Д.Дамдинтогтох ("Мэдээлэл Холбоо сүлжээ" ТӨХК-ийн Өвөрхангай газрын Хужирт салбарын эрхлэгч инженер)

Э.Лхагвасүрэн (Зураг төслийн "Арвай проект" ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч: Н.Шинэ-Эрдэнэ ("Сонор Гуа Солюшн" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)